

**ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТ
ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ
АСУУДЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот


Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Олон улсын валютын сангийн ерөнхий хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг зөвшилцөхөөр ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг асуудлыг хэлэлцүүлэхэд Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, Д.Дэмбэрэл нар ажлын хэсгээс асуулт асууж хариулт авсан болно.

Олон улсын валютын сангийн ерөнхий хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу энэхүү санал, дүгнэлтийг гаргасан болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР